



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/355

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, тендер
хүчингүй болгож, шууд гэрээ
байгуулах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.4.3, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр зөвлөмжийн дагуу Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт 2023 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендерийн 1 дүгээр багц Нянгийн эсрэг бусад бүлгийн антибиотикүүдыг 17,140,000 (арван долоон сая нэг зуун дөчин мянга) төгрөгөөр Энто ХХК-иар, 11 дүгээр багц Цус сийвэн орлох, цусны бүлэгнэлтэд нөлөөлөх эмүүдийг 20,019,700 (хорин сая арван есөн мянга долоон зуу) төгрөгөөр Энто ХХК-иар, 16 дугаар багц Иод спирт агуулсан ариутгал халдваргүйтгэлийн бодисыг 9,532,000 (есөн сая таван зуун гучин хоёр мянга) төгрөгөөр Мөнхийн тун ХХК-иар, 22 дугаар багц Нэг удаагийн тариурыг 22,830,750 (хорин хоёр сая найман зуун гучин мянга долоон зуун тавь) төгрөгөөр Мөнхийн тун ХХК-иар, 23 дугаар багц Нэг удаагийн тариурыг 16,769,000 (арван зургаан сая долоон зуун жаран есөн мянга) төгрөгөөр Мөнхийн тун ХХК-иар тус тус гүйцэтгүүлсүгэй.

2. Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн 18 дугаар багц Лабораторийн урвалж, нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй 3 дугаар багц Цусны даралт бууруулах, шээс хөөх эм болон зүрх судасны эм, Амин дэм эрдэс бодис, харшилын эсрэг эм, 4 дүгээр багц Чих болон нүд харшлын эмүүд, 6 дугаар багц Тархины цусан хангамж сайжруулах, үрэвслийн эсрэг өвчин намдаах, дааврын болон спазмолитик эмүүд, 8 дугаар багц Инсулин ба чихрийн шижингийн эсрэг эмүүд (тариуртай), 10 дугаар багц Мансууруулах, сэтгэцэд нөлөөт болон хүчтэй үйлдэлтэй өвчин намдаах, мэдээгүйжүүлэх уналт таталтын эсрэг эмүүд, 13 дугаар багц Судсаар сэлбэх тарилгын шингэнүүд (дотоодын үйлдвэр), 15 дугаар багц Халдваргүйжүүлэх болон үжлийн эсрэг бодис, 17 дугаар багц Халдваргүйтгэлийн бодис, 19 дүгээр багц Уламжлалт эм, 21 дүгээр багц Эх барих эмэгтэйчүүдийн эм, Жирэмслэлтээс сэргийлэх эм, хэрэгслэл багцуудыг тус тус хүчингүй болгосугай.

3. Дээрх тендерийн гүйцэтгэгч шалгарсан болон хүчингүй болсон багцуудад гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавин, гэрээнд заасан хугацаанд хүлээн авч, гэрээний хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч (Д.Энхзаяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0686

D:My Doc. Zahiramj. Zasag darga